

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2023 он



Сэндбоксад бүтээгдэхүүн,
үйлчилгээгээ турших хүсэлтэй
байгууллагуудад зориулан
боловсруулав.

1

Сэндбокс зохицуулалт
гэж юу вэ?

2

Сэндбоксын
зохицуулалт олон
улсад

3

Сэндбоксад орох
шаардлагатай юу?

4

Хүсэлт гаргагчдад
тавигдах шаардлага,
бүрдүүлэх материал

5

Сэндбоксын шийдвэр
гаргалтын
процесс

6

Сэндбоксын зөвлөл,
алба

7

Сэндбоксад
бүтээгдэхүүн,
үйлчилгээгээ турших

8

Сэндбоксоос
гаргах

9

Сэндбоксоос зах
зээлрүү шилжих

10

Анхаарах зүйлс,
хавсралт



Эхэлцгээе!

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

“Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк /цаашид “санхүүгийн зохицуулагч байгууллага” гэх/-ны хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших зохицуулалтын орчныг сэндбокс зохицуулалт гэнэ”

Сэндбокс зохицуулалтын давуу тал:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ инкубатор, хиймэл загварт бус бодит орчинд турших боломжийг олгоно;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд амьдрах чадвар болон тулгарч болох эрсдэлийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр зах зээлд нийлүүлэх боломж бүрдэнэ;
- Зохицуулалтын орчноор хязгаарлагдахгүйгээр, эсхүл шаардлагатай зохицуулалтын орчин бүрдэх хугацааг хүлээлгүйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэвтрүүлэх боломжийг олгоно;
- Зах зээлд анхдагч оролцоотой байх хүртээмжтэй, ухаалаг санхүүгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдэнэ.



СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД


Сэндбоксыг зохицуулалтын орчин нь 2016 онд анх Их Британи Улсад үүсэж хөгжсөн бөгөөд өдгөө дэлхийн улс орнууд сэндбоксын зохицуулалтыг санхүүгийн зах зээлд хурдацтай нэвтрүүлсээр байна.

Зураг 1. Сэндбоксыг зохицуулалтыг нэвтрүүлсэн улс орнууд, 2020 оны байдлаар




2020 оны Дэлхийн банкны судалгаагаар 2016-аас 2020 оны хооронд нийт 57 улс 76 төрлийн сэндбокс орчинд технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг туршиж байна.

Зураг 2. Сэндбоксыг зохицуулалтад нэвтэрч буй технологийн шийдлүүд



Олон улсад нэвтрүүлж буй сэндбоксын орчныг зориулалтаар нь ангилан харвал 63 хувь нь технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ 10 хувь нь блокчэйн технологийн хөгжлийг дэмжих, 8 хувь нь технологид суурилсан даатгалын үйлчилгээ буюу инсуртек, 8 хувь нь төлбөр тооцооны үйлчилгээ, 5 хувь нь хэрэглэгчийг таних технологи, 3 хувь нь регтек үлдсэн 3 хувь нь бусад төрөлд хамаарч байна.


Зураг 3. Улс орнуудын сэндбокс туршилтаас гарч буй үр дүн



Харин сэндбокс орчноос амжилттай туршигдаж гарсан бүтээгдэхүүн үйлчилгээний 50 гаруй хувийг шууд зах зээлд нэвтрүүлэхэд уламжлалт зохицуулалт тохиромжгүй байсан тул хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийсний дараа зах зээлд нэвтрүүлэхээр болсон бол 38 хувийг нь бүртгэж, тусгай зөвшөөрөл олгон зах зээлд нэвтрүүлсэн.

Энэ нь технологид суурилсан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээнд уламжлалт хууль эрх зүйн орчин тохиромжгүй байгааг харуулж байна. Харин үлдсэн буюу бүтээгдэхүүн үйлчилгээний 8 хувийн бизнесийн загварыг өөрчилж дахин сэндбокс орчинд туршсан байна.

Зураг 4. Зарим улс орнуудад хөгжүүлж буй сэндбокс




Сүүлийн жилүүдэд улс орнууд өөрсдийн санхүүгийн салбар, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогт тохируулан уламжлалт сэндбоксын орчноос гадна 2-оос 3 өөр төрлийн сэндбоксын орчныг нэвтрүүлж байна. Тухайлбал, 2016 онд Сэндбоксын эрх зүйн орчныг анх бүрдүүлсэн Их Британи улс нь 2020 онд нэмж Дижитал сэндбоксыг бий болгосон.

Харин Сингапур улс нь 2016 онд сэндбокс, 2019 онд сэндбокс экспресс, 2022 онд сэндбокс пласыг нэвтрүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

СЭНДБОКСОД ОРОХ ШААРДЛАГА БИЙ ЮУ?

Та өөрийн компанийн хөгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбоксоод турших шаардлагатай эсэхийг доорх графикаас мэдэх боломжтой.



ХҮСЭЛТ ГАРГАГЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Сэндбоксын оролцогчдод тавигдах шаардлага, сэндбоксын орчинд турших боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээ болон сэндбоксын орчинд туршигдах бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагатай та “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын II бүлгийг уншсанаар танилцах боломжтой.



Санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа, эсхүл ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад санхүүгийн зах зээл болон хэрэглэгчийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлсэн.



Шинээр нэвтрүүлж буй технологи, шийдэлтэй холбогдуулан зохицуулалтын орчин бүрдээгүй, эсхүл одоо байгаа зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн.



Санхүүгийн зохицуулалтын орчинд шинээр нэвтэрч буй технологийн шийдэл буюу регтек.



Санхүүгийн зохицуулагч байгууллага болон бодлого гаргагчдын зүгээс тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор санал болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад.



Харин Сэндбоксын орчинд “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 2.3-т заасан шаардлагыг хангаагүй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон 4.1-т заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй хүсэлт гаргагчдыг оруулахгүй.

Сэндбоксад дараах
бүтээгдэхүүн, үйлчилгээг
хамруулна:



ХҮСЭЛТ ГАРГАГЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Сэндбоксын оролцогчдод болон сэндбоксад турших гэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага:

Сэндбоксын оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна →



1.Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
2.Сэндбоксын хугацаанд үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг нөхөн төлөх санхүү, төлбөрийн чадвартай;

3.Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;
4.Хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнууд нь мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдоогүй байх.

5.Хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны эсэхийг тодорхойлох боломжтой бөгөөд татвар төлсөн.

Сэндбоксад турших бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна →



1.Санхүүгийн тогтвортой байдал эрсдэл учруулахааргүй;
2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;

3.Санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчийн хүртэх үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;
4.Хэрэгжих боломжтой байдал болон техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн үр ашгийн тооцоо хийгдсэн;

5.“Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан технологийн шаардлагыг хангасан;
6.Сэндбоксын хүрээнд хэрэглэгчид санал болгоход бэлэн болсон, технологийн хөгжүүлэлт нь шаардлагатай хэмжээнд хийгдсэн.

Амжилт



Хэрэв та өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сэндбоксын орчинд туршихаар шийдсэн бол сэндбоксын оролцогчдод болон турших гэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагатай сайтар танилцан уг шаардлагуудыг хангаж буй болохоо бизнес төлөвлөгөө болон бусад баримт бичгийн хамтаар нотлон харуулах шаардлагатай.

ТЕХНОЛОГИЙН ШААРДЛАГА



Сэндбоксад оролцохоор хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь дараах технологийн шаардлагуудыг хангасан байна:

- ✓ Хоёрдугаар түвшний (Tier 2) стандартын дата төвтэй, эсхүл энэ стандартыг хангасан дата төвд системийг байршуулсан байх;
- ✓ Хэрэглэгчийн мэдээллийг нийтийн болон хувийн сүлжээгээр дамжуулахдаа шифрлэн нууцалсан байх;
- ✓ Албан ёсны эрх бүхий вирусээс хамгаалах програм хангамж ашигладаг байх;
- ✓ Нууцлал, аюулгүй байдлын систем болон програм хангамж хөгжүүлж ашигласан байх;
- ✓ Хэрэглэгчийн мэдээлэлд нэвтэрч буй бүх хандалтыг хянаж, бүртгэдэг байх;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын бодлоготой байх.

Турших гэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог, технологийн шийдэлд тохируулан дараах материалуудыг Сэндбоксын албанд ирүүлнэ:

- ✓ Ашиглаж буй технологи, тоног төхөөрөмжийн жагсаалт, танилцуулга;
- ✓ Хэрэглэгч болон сервер талуудыг хамруулсан сүлжээ болон програм хангамжийн бүтэц схем (topology schema);
- ✓ Технологи хариуцсан алба ажилчдын чиг үүрэг, танилцуулга;
- ✓ Систем хөгжүүлэлтийн зардал;
- ✓ Өгөгдлийн санд ашигласан технологийн мэдээлэл;
- ✓ Систем хооронд ашиглагдаж буй сервисийн жагсаалт;
- ✓ Систем, хэрэглэгч болон үйл ажиллагааны гарын авлагууд;
- ✓ Системийн ачаалал даах чадварын тайлан;
- ✓ Нууцлал, аюулгүй байдлыг хангах хүрээнд хийгдсэн ажлын жагсаалт;
- ✓ ISO27001 стандарт, эсхүл Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

“Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.1-т заасны дагуу сэндбоксад орох хүсэлтэй байгууллагууд нь дараах баримт бичгийг бүрдүүлэн WWW.LICENSE.FRC.MN цахим хаягаар хүсэлтээ гаргана:



- Сэндбоксад орох хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;
- “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.3-т заасны дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө; /бизнес төлөвлөгөөнд тавигдах шаардлагыг хавсралтаас харна уу/
- “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.4-т заасны дагуу боловсруулсан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;
- Мэдээллийн аюулгүй байдлын журам;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдүүд тус хуулийн 14.4-т заасан дотоод хяналтын хөтөлбөр;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д хамааралгүй этгээдүүд бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх арга хэлбэр болон хэрэглэгчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн журам;
- Санхүүгийн тайлан, эсхүл эхлэлийн тайлан тэнцэл;
- “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 2.1-д заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримтыг хавсаргах.

Сэндбоксын алба нь хүсэлтийг хүлээн авч, хянах явцад хуулийн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардаж болох бөгөөд дээр заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй, эсхүл ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд сэндбоксын орчинд оруулах боломжгүй болохыг анхаарна уу.


СЭНДБОКСЫН ЕРӨНХИЙ ПРОЦЕСС



СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛ, АЛБА

Сэндбоксын алба нь сэндбоксын орчинд орох, сэндбоксын туршилтын хугацааг сунгах, сэндбоксоос гарах хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлд хамаарах салбарын бодлого, хяналтын албан хаагчид /цаашид “чиглэл хариуцсан албан хаагч” гэх/-тай хамтран санал дүгнэлт боловсруулан Зөвлөлд танилцуулна. Сэндбоксоод турших бүтээгдэхүүн, үйлчилгээ нь банкны үйл ажиллагаа, төлбөрийн системд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ байх тохиолдолд Сэндбоксын алба нь мөн Монголбанкны холбогдох албан хаагчидтай хамтран ажиллана.

Сэндбоксын албаны боловсруулсан дүгнэлтэд үндэслэн Сэндбоксын зөвлөл нь сэндбоксоод оруулах, туршилтын хугацааг сунгах, сэндбоксоос гарах шийдвэр, зөвлөмжийг гарган холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагуудад хүргүүлнэ.



Сэндбоксын зөвлөлийн бүрэн эрх:

- Сэндбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн сэндбоксын нөхцөл, хязгаарлалтыг тодорхойлж, сэндбоксоод оруулах эсэх зөвлөмжийг гарган холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлэх;
- Сэндбокс дуусгавар болох үед холбогдох зөвлөмжийг гаргах;
- Сэндбоксоод амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтын орчны талаарх зөвлөмж гаргах;
- сэндбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын санал дэвшүүлэх.


Сэндбоксын зөвлөлийн бүрэлдэхүүн:

- Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголбанк /цаашид “санхүүгийн зохицуулагч байгууллага” гэх/-ны төлөөлөл;
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- судлаач, эрдэмтдийн төлөөлөл;
- санхүү, мэдээлэл технологийн салбарын төлөөлөл.

СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛ, АЛБА

Сэндбоксын албаны чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Сэндбоксад орох, сэндбоксын туршилтын хугацааг сунгах, сэндбоксоос гарах хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран санал, дүгнэлт боловсруулан Зөвлөлд танилцуулах;
- Оролцогчийн сэндбоксын хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, бизнес төлөвлөгөөтэй танилцан шаардлагатай тохиолдолд холбогдох саналыг бизнес төлөвлөгөөнд тусгуулах;
- Оролцогчдыг бүртгэн тэдгээрийн үйл ажиллагаанд чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллах;
- Сэндбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан санхүүгийн зах зээлийн талаар холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санал боловсруулах.



СЭНДБОКСЫН ОРЧИНД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ТУРШИХ



**СЭНДБОКСЫН
ТУРШИЛТЫН ХУГАЦАА
НЬ 1 ЖИЛ ХҮРТЭЛ БАЙХ
БА ОРОЛЦОГЧИЙН
ХҮСЭЛТИЙГ ҮНДЭСЛЭН
1 ЖИЛ ХҮРТЭЛ
ХУГАЦААГААР НЭГ УДАА
СУНГАЖ БОЛНО.**

Сэндбоксын орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээлд цоо шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ тул үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сэндбоксын зөвлөл нь оролцогчийн заавал байлгах нөөц хөрөнгийн хэмжээ, хохирол нөхөн төлөхөд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээг тогтоох болон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох зах зээлийн хүрээ, хэрэглэгчдийн тоо, нутаг дэвсгэр, нэг удаа, эсхүл нийт хийгдэх гүйлгээний тоо, хэмжээ зэрэг үзүүлэлтүүдэд хязгаарлалт тавьж болох бөгөөд оролцогч нь сэндбоксын туршилтын хугацаанд уг хязгаарлалтыг заавал мөрдөж ажиллана.

Мөн сэндбоксын оролцогч нь сэндбоксын туршилтын хугацаанд үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг хэмжигдэхүйц байдлаар урьдчилан тогтоож бизнес төлөвлөгөөндөө тусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд оролцогчийн санал болгосон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд дээр Сэндбоксын зөвлөл нь нэмэлт, өөрчлөлт оруулан эцэслэнэ.

Оролцогч нь сэндбоксын туршилтын хугацаанд урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөн ажиллах бөгөөд сэндбоксын хугацаа дуусгавар болох үед сэндбоксын туршилт амжилттай болсон эсэхийг эдгээр гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд дээр суурилан дүгнэнэ.

СЭНДБОКСЫН ОРЧИНД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ТУРШИХ

ОРОЛЦОГЧ НЬ СЭНДБОКСОД ДАРААХ ШААРДЛАГЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАНА

- Оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид санал болгохдоо санхүүгийн зохицуулагч байгууллагаас тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл аваагүй буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбоксын орчинд туршиж байгаа болон учирч болох бусад эрсдэлийн талаар урьдчилан танилцуулж, хэрэглэгчтэй байгуулах гэрээнд тусгах үүрэгтэй.
- Оролцогчийн хэрэглэгчтэй байгуулах гэрээ нь төөрөгдүүлэхүйц, хоёрдмол утга агуулаагүй, ойлгомжтой байх бөгөөд гэрээний нөхцөлтэй хэрэглэгч бүрэн танилцсан тухай болон дээр дурдсан нөхцөлийг урьдчилан мэдэгдсэн талаар оролцогч нь харилцагчаар гарын үсэг зуруулан баталгаажуулна.
- Оролцогч нь хэрэглэгчид болон тэдгээрт хүргэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тогтмол бүртгэн мэдээллийн сан үүсгэж, нууцлалын аюулгүй байдлыг ханган ажиллана.

Оролцогч нь сэндбоксын орчинд зөвхөн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээг туршина.

Сэндбоксын оролцогч нь доорх шаардлагыг хангасан сэндбоксоод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тайлан, мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор, шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос хамааруулан сарын мэдээг дараа сарын 5-ны дотор Сэндбоксын албанд ирүүлнэ:

- Тайлангийн агуулга хэлбэр, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой статистик мэдээлэл, хэмжигдэхүүнийг урьдчилан тодорхойлж, тайланг ойлгомжтой байдлаар боловсруулах;
- Туршилтын явцад гарсан гомдол маргаан болон технологийн эвдрэл, гэмтлийг тухай бүрд бүртгэж, шийдвэрлэсэн байдлыг дэлгэрэнгүй тусгах;
- Туршилтын явцад нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчны өөрчлөлтөөс шалтгаалан хүндрэл бэрхшээл үүссэн бол түүнийг шийдвэрлэх хариу арга хэмжээг тусгах;
- Туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой орлого, үр дүнгийн дэлгэрэнгүй тайлан.

Оролцогчдод зайны болон газар дээрх хяналт шалгалтыг холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлэх ба Сэндбоксын алба хамтран оролцоно.

СЭНДБОКСООС ГАРАХ



СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧ НЬ ДАРААХ ТОХИОЛДЛУУДАД СЭНДБОКСООС ГАРНА:

- Оролцогчийн сэндрбоксын туршилтын хугацаа дуусгавар болсон;
- Оролцогч өөрийн хүсэлтээр гарах санал ирүүлсэн; эсхүл
- Оролцогчийг хугацаанаас өмнө гаргах нөхцөл бүрдсэн тохиолдсон.

Дараах тохиолдол нь оролцогчийг хугацаанаас өмнө сэндрбоксоос гаргана:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээг гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан болох нь тогтоогдсон;
- Оролцогч нь Зөвлөлийн зөвлөмжид заасан хязгаарлалтыг зөрчсөн, шаардлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй;
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагыг зөрчсөн, эсхүл оролцогчийн үйл ажиллагаанаас бий болсон гомдол, зөрчил, технологийн эвдрэл гэмтлийг засаж сайжруулах, учирсан хохирлыг нөхөн төлөх боломжгүй болсон;
- Оролцогч нь санхүүгийн зохицуулагч байгууллага болон хэрэглэгчид төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгсөн, эсхүл мэдээллийг нуун дарагдуулсан нь тогтоогдсон;
- Оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь “Сэндрбокс зохицуулалтын орчны журам”-ын 2.3-т заасан шаардлагад нийцэхгүй болсон.

Оролцогч сэндрбоксын туршилтын хугацаа дуусгавар болох үед 30-аас доошгүй хоногийн өмнө сэндрбоксоос гарах хүсэлтээ Сэндрбоксын албанд хүргүүлэх ба оролцогчийн хүсэлт, Сэндрбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн Зөвлөл зөвлөмжийг ажлын 10 өдрийн дотор санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

- Сэндрбоксоос хугацаанаас нь өмнө гаргах нөхцөл бүрдсэн тохиолдолд оролцогчид урьдчилан мэдэгдэх бөгөөд оролцогч нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох тайлбар, нотлох баримт бичгийг ирүүлнэ. Тайлбар, нотлох баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд Сэндрбоксын алба нь холбогдох санал, дүгнэлтийг гаргаж, Зөвлөлд танилцуулна.

Оролцогчийн сэндрбоксын туршилт нь амжилтгүй болж, сэндрбоксоос гаргах шийдвэр гарсан тохиолдолд “Сэндрбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.1.4, 4.3.6-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэн хэрэглэгчдэд үйл ажиллагаа дуусгавар болсон талаар мэдэгдэх, хэрэглэгчийн санхүүгийн хохирлыг барагдуулах, сэндрбоксын орчинд цуглуулсан хэрэглэгчдийн бүх мэдээллийг задруулахгүйгээр устгах зэрэг холбогдох арга хэмжээг нэн даруй авна.



СЭНДБОКСООС ЗАХ ЗЭЭЛРҮҮ ШИЛЖИХ

Оролцогчийн сэндроксын туршилт нь Зөвлөлөөр амжилттай буюу цаашид зах зээлд нэвтрэх боломжтой гэж дүгнэгдсэн тохиолдолд оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд нэвтрүүлэх бөгөөд “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-д заасны дагуу сэндрокс амжилттай хэрэгжсэний дараа зах зээлд нэвтрэх шилжилтийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлнэ.



- Шилжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат нь 6 сар хүртэл хугацаатай байна. Оролцогч нь энэ хугацаанд Зөвлөлөөс тогтоосон нөхцөл, шаардлага, хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.



- Сэндроксын алба, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран сэндроксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.



- Шилжилтийн хугацаа дуусгавар болох үед тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран Санхүүгийн зохицуулах хорооны дарга, эсхүл Монголбанкны Ерөнхийлөгч сэндроксоос гаргах шийдвэрийг гаргана.



- Оролцогч сэндроксоос гарснаас хойш 30 хоногийн дотор Сэндроксын албанд дараах тайланг ирүүлнэ:

–сэндроксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөнд заасан арга хэмжээний тайлан;

–сэндроксод оролцсоноор гарсан үр дүн, хэрэглэгчид тухайн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрхэн хүлээж авсан, хэрэглэгчтэй холбоотой гомдол, маргаан сэндроксын хугацаанд гарсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн, хэрэв сэндроксын туршилт амжилтгүй болсон бол түүний шалтгаан, үр дагаврын талаарх мэдээлэл бүхий тайлан.

АНХААРАХ ЗҮЙЛС



Сэндбоксад оролцож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үүдэн хэрэглэгчдэд үүссэн хохирлыг оролцогч тал дангаараа хариуцна.

- Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндбоксад амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- Санхүүгийн зохицуулагч байгууллага нь оролцогчид болон олон нийтийг сэндбокс зохицуулалтын талаарх зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж ажиллана.
- Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндбоксын ил тод байдал болон хэрэглэгчдийг мэдээллээр хангах үүднээс оролцогчийн нэр, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, сэндбоксын эхлэх, дуусах хугацааг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн байна.
- Санхүүгийн зохицуулагч байгууллага нь хүсэлт гаргагч болон оролцогчидтой холбоотой аливаа мэдээллийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хадгалж, хамгаална.

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Бизнес төлөвлөгөөг 1 жилийн хугацаатай боловсруулах бөгөөд эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь хоорондоо уялдаатай, үнэн бодитой, үр дүн нь цаг хугацаандаа хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна.

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ хэсэгт дараах мэдээллийг тусгана:



⇒ компанийн байгуулагдсан огноо, үйл ажиллагааны чиглэл, өмнө нь эрхэлж байсан бизнес, компанийн түүх, ололт амжилтын талаар;



⇒ одоогийн явуулж буй үйл ажиллагаа, бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтэц бүрэлдэхүүний талаар; /Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй/



⇒ байгууллагын боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын багийн танилцуулга, тэдний өмнө хийж байсан ажил, ажлын туршлага, одоогийн хариуцан ажилладаг ажлын талаар бичих. Байгууллагын зохион байгуулалтын бүтцийг схемчлэн зурж болно.

Эрхэм зорилго, зорилт: Энэ хэсэгт ямар зорилтот бүлгийн ямар хэрэгцээг яаж хангах тухай болон эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хугацаатай, төлөвлөгөөтэй хийгдэх ажлуудын үр дүнгийн тухай бичнэ.



II. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Энэ хэсэгт дараах мэдээллийг тусгана:



⇒ Бүтээгдэхүүн үйлчилгээний дэлгэрэнгүй танилцуулга, түүний давуу болон сул тал, үйлчилгээний процессын зураглал, хэрэглэгчид санал болгоход бэлэн болсон эсэх болон технологийн шийдэл, платформын хөгжүүлэлтийн талаар дэлгэрэнгүй бичих;



⇒ Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа, эсхүл ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад санхүүгийн зах зээл болон хэрэглэгчийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх эсэхийг тодорхойлох.

III. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Зах зээлийн ерөнхий чиг хандлага: Энэ хэсэгт зах зээлийн хүрээ, хэрэглэгчдийн тоо хэмжээ, тухайн хуулийн этгээдийн зах зээлд эзлэх хувь, зах зээлийн өсөлт, ирээдүйн төлөв байдал, зах зээлд гарч буй өөрчлөлтийн талаар бичих бөгөөд технологийн хөгжил, байгалийн хүчин зүйлс, хүн амын суурьшилт зэргийг тодруулна.

Бизнесийн хууль эрх зүйн орчин: Тухайн бизнесийг эрхлэхтэй холбоотой хуулиудыг судалсан эсэх, тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг зохицуулах зохицуулалтын орчин бүрдсэн эсэх, эсхүл тухайн үйлчилгээг зах зээлд санал нэвтрүүлэхэд саад болж буй хязгаарлалтын тухай тодорхой бичнэ.

Өрсөлдөөн, өрсөлдөгчид: Тухайн зах зээл дээрх ижил төрлийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоо хэмжээ, нэр, хүчин чадал, зах зээлд эзлэх хувь, давуу болон сул талуудын талаар дурдана. Сэндбоксоод санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний давуу, сул тал, боломжуудыг урьдчилан шинжлэх SWOT шинжилгээг хийх.

Компанийн дотоод хүчин зүйлс

Давуу тал	Сул тал
⇒	⇒
⇒	⇒

Компанийн гадаад хүчин зүйлс

Давуу тал	Сул тал
⇒	⇒
⇒	⇒

IV. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны төлөвлөгөө: Энэ хэсэгт бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох зах зээлийн хүрээ, хэрэглэгчдийн тоо, нутаг дэвсгэр, нэг удаа, эсхүл нийт хийгдэх гүйлгээний тоо, хэмжээг тодорхойлж, тооцоолол хийнэ.

Төлөвлөгөөт ажил	ОН											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII

- 1.
- 2.
- 3.
- 4.
- ...

Маркетингийн төлөвлөгөө: Энэ хэсэгт өмнөх бүлэгт хийсэн зах зээл, хэрэглэгчдийн судалгааг үндэслэн бүтээгдэхүүн, үйлчилгээг идэвхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Үүнд: Бүтээгдэхүүн (үйлчилгээ), Үнэ (үнийг хэрхэн тогтоох), Байрлал (суваг, хуваарилалт), Идэвхжүүлэлт (зар сурталчилгаа) зэргийг хэрхэн шийдвэрлэснээ тодорхойлно.

Санхүүгийн төлөвлөгөө: Санхүүгийн төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардал, ашиг, алдагдлыг тооцож, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана.

V. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт сэндрбоксоод туршигдах хугацаанд тухайн үйлчилгээ/үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг өөрийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, харьяалагдах санхүүгийн дэд салбараас хамааруулан хэмжигдэхүйц байдлаар тодорхойлно. Эдгээр тодорхойлж буй үзүүлэлтүүд нь сэндрбоксоос амжилттай гарах эсэхийг тодорхойлоход ашиглагдахыг анхаарна уу.



VI. СЭНДБОКСООС ГАРАХ ТӨЛӨВЛӨГӨӨ


Энэ хэсэгт сэндрбоксын туршилт амжилтгүй болсон тохиолдолд авах дараах арга хэмжээний талаар тусгана:

- ⇒ хэрэглэгчдэд үйл ажиллагаа дуусгавар болсон талаар хэрхэн мэдэгдэх талаар;
- ⇒ хэрэглэгчтэй холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэж ямар процессоор хэрэглэгчийн санхүүгийн хохирлыг барагдуулах талаар;
- ⇒ сэндрбоксын орчинд цуглуулсан хэрэглэгчдийн бүх мэдээллийг задруулахгүйгээр устгах, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар.



VII. ШИЛЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ хэсэгт сэндрбоксын туршилт амжилттай болж зах зээлд шилжих үе шатыг нарийвчлан тодорхойлж, хүний нөөц нэмэгдүүлэх, техник технологийн хөгжүүлэлт хийх зэрэг авах арга хэмжээг тодорхой тусгана.



ХОЛБОО БАРИХ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН
ГАЗАР, СЭНДБОКСЫН АЛБА

УТАС: 51-261106

И-МЭЙЛ: SANDBOX@FRC.MN

ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН IV БАЙР, БАГА
ТОЙРУУ 3, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР ХОТ, 15160

@САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО